



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тужийн нарсны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022/227-НА-СТА-ТШЗ

| | | |
|---|--|---|
| Цахим хуудас: www.selenge.audit.gov.mn | Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Аудитор: Утас: 7036-3036 | Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn Ж.Цогт Цахим хаяг: Tsogtj@audit.gov.com |
|---|--|---|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

| | |
|---|-----|
| 1. Аудитын санал дүгнэлт..... | 3-4 |
| 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл | 5 |
| 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан..... | 5 |
| 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан..... | 6-7 |
| 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан..... | 8-9 |
| 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан..... | 10 |
| 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан..... | 11 |
| 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан..... | 12 |
| 3. Аудитын тайлан..... | 13 |
| 3.1 Ерөнхий зүйл..... | 13 |
| 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт..... | 13 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал | 14 |
| 3.4 Материаллаг байдал | 14 |
| 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга..... | 15 |
| 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв..... | 16 |
| 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг | 17 |
| 3.8 Аудитын гол асуудал | 17 |
| 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал..... | 17 |
| 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт | 18 |
| 3.11 Хойших үйл явдал ба дараагийн аудитаар анхаарах асуудал..... | 18 |
| 4. Аудитын илрүүлэлт | 19 |
| 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл..... | 20 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| БОАЖЯ | Байгаль орчин, аялал жуулчлалын яам |
| НА | Нотлох аудит |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| СЭА | Сэлэнгэ аймаг |
| ТББ | Төрийн бус байгууллага |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.02.14 № *СЭА-2022/227-НА-СТА-ТШЗ*
танай _____-ны № _____-т

Г ТУЖИЙН НАРСНЫ БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ ГАЗРЫН ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААНЫ ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Н.ӨЛЗИЙБАЯР ТАНАА

Г АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ Г

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тужийн нарсны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тужийн нарсны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|------------|---|-----------------------|-----------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 22,141,070.45 | 31,847,795.84 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 22,141,070.45 | 31,847,795.84 |
| 351 | Түүхий эд материал | 3,377,789.20 | 3,014,576.59 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 3,377,789.20 | 3,014,576.59 |
| 35200 | Дуусаагүй үйлдвэрлэл | 715,000.00 | 870,000.00 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 166,624.25 | 138,224.25 |
| 354 | Хангамжийн материал | 17,881,657.00 | 27,824,995.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 226,662.00 | 684,320.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 13,140,600.00 | 6,017,600.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 830,000.00 | 1,165,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 3,684,395.00 | 19,958,075.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 189,261,884.08 | 237,230,045.51 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 189,261,884.08 | 237,230,045.51 |
| 392 | Биет хөрөнгө | 145,241,884.08 | 193,260,045.55 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 105,054,224.67 | 137,209,013.67 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (13,136,365.94) | (19,226,079.50) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 48,297,500.00 | 90,937,500.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (25,423,263.80) | (36,171,763.79) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 57,963,538.46 | 58,961,308.46 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (35,440,365.28) | (46,132,219.70) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 9,397,438.43 | 11,627,338.43 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (5,177,486.50) | (6,712,603.62) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 11,152,355.20 | 10,740,355.20 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (7,445,691.16) | (7,972,803.60) |
| 393 | Биет бус хөрөнгө | 44,020,000.00 | 43,969,999.96 |
| 39301 | Програм хангамж | 100,000.00 | 100,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | - | (50,000.04) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 43,920,000.00 | 43,920,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 211,402,954.53 | 269,077,841.35 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 211,402,954.53 | 269,077,841.35 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 211,402,954.53 | 269,077,841.35 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 143,918,285.24 | 143,918,285.24 |
| 51101 | Өмч: - төрийн | 143,918,285.24 | 143,918,285.24 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | (7,502,991.95) | 50,171,894.87 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (7,502,991.95) | (7,502,991.95) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 57,674,886.82 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 74,987,661.24 | 74,987,661.24 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 211,402,954.53 | 269,077,841.35 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|------------|--|-----------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 238,763,725.00 | 314,220,315.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 27,200,125.00 | 76,198,795.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 27,200,125.00 | 76,198,795.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 15,402,625.00 | 584,006.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 15,402,625.00 | 584,006.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | 11,797,500.00 | 74,794,789.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | - | 820,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 211,563,600.00 | 238,021,520.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 200,063,600.00 | 227,118,700.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 200,063,600.00 | 227,118,700.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 11,500,000.00 | 10,902,820.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 11,000,000.00 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 500,000.00 | 10,902,820.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 242,009,074.33 | 256,545,428.18 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 242,009,074.33 | 256,545,428.18 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 223,993,460.33 | 213,099,131.18 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 117,443,752.00 | 111,232,334.00 |
| 210101 | Үндсэн цалин | 78,737,330.00 | 82,171,994.00 |
| 210102 | Нэмэгдэл | 29,650,400.00 | 25,973,940.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 3,054,674.00 | 3,086,400.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 6,001,348.00 | - |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 14,835,046.00 | 14,322,737.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 10,521,814.00 | 10,258,581.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,170,801.00 | 1,141,724.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 944,322.00 | 889,859.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 199,831.00 | 184,780.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,998,278.00 | 1,847,793.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 9,864,430.00 | 8,152,636.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 590,130.00 | 600,878.00 |
| 210302 | Түлш, халаалт | 8,885,900.00 | 7,039,858.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 388,400.00 | 511,900.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 11,600,757.75 | 10,047,874.61 |
| 210401 | Бичиг хэрэг | 808,476.00 | 577,592.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 8,561,700.00 | 6,625,100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,400,600.00 | 1,154,300.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 93,600.00 | 93,600.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 460,200.00 | 725,070.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 276,181.75 | 872,212.61 |

Тужийн нарсны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | |
|--------|---|-----------------------|----------------------|
| 2105 | Нормативт зардал | 205,900.00 | 3,445,900.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 205,900.00 | 3,445,900.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 653,000.00 | 480,100.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 153,000.00 | 30,100.00 |
| 210604 | Урсгал засвар | 500,000.00 | 450,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,659,800.00 | 1,439,800.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,659,800.00 | 1,439,800.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 37,689,348.00 | 31,683,122.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 36,505,293.00 | 30,580,502.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 432,000.00 | 432,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 151,600.00 | 148,200.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 65,835.00 | 126,100.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 66,000.00 | 77,400.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 424,700.00 | 275,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 43,920.00 | 43,920.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 30,041,426.58 | 32,294,627.57 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,836.00 | 28,400.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 30,039,590.58 | 32,266,227.57 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 18,015,614.00 | 43,446,297.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | - | 34,745,700.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | - | 400,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 34,345,700.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 18,015,614.00 | 8,700,597.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | <u>(3,245,349.33)</u> | <u>57,674,886.82</u> |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | <u>(3,245,349.33)</u> | <u>57,674,886.82</u> |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан


| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--|-----------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 226,966,225.00 | 238,605,526.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 15,402,625.00 | 584,006.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 15,402,625.00 | 584,006.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 15,402,625.00 | 584,006.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 15,402,625.00 | 584,006.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 211,563,600.00 | 238,021,520.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 200,063,600.00 | 227,118,700.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 200,063,600.00 | 227,118,700.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 11,500,000.00 | 10,902,820.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 11,000,000.00 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 500,000.00 | 10,902,820.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 224,238,650.00 | 233,165,926.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 224,238,650.00 | 233,165,926.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 206,223,036.00 | 189,719,629.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 117,443,752.00 | 111,232,334.00 |
| 210101 | Үндсэн цалин | 78,737,330.00 | 82,171,994.00 |
| 210102 | Нэмэгдэл | 29,650,400.00 | 25,973,940.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 3,054,674.00 | 3,086,400.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 6,001,348.00 | - |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 14,835,046.00 | 14,322,737.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 10,521,814.00 | 10,258,581.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,170,801.00 | 1,141,724.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 944,322.00 | 889,859.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 199,831.00 | 184,780.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,998,278.00 | 1,847,793.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 9,864,430.00 | 8,152,636.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 590,130.00 | 600,878.00 |
| 210302 | Түлш, халаалт | 8,885,900.00 | 7,039,858.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 388,400.00 | 511,900.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 11,507,900.00 | 8,816,320.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 689,300.00 | 466,900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 8,816,700.00 | 6,370,100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,400,600.00 | 1,182,500.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 93,600.00 | 93,600.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 507,700.00 | 703,220.00 |
| 2105 | Нормативт зардал | 205,900.00 | 5,147,900.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 205,900.00 | 5,147,900.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 653,000.00 | 480,100.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 153,000.00 | 30,100.00 |
| 210604 | Урсгал засвар | 500,000.00 | 450,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,659,800.00 | 1,439,800.00 |

Тужийн нарсны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | |
|-------------|--|------------------------------|------------------------------|
| 210702 | Дотоод албан томилолт | 1,659,800.00 | 1,439,800.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 50,053,208.00 | 40,127,802.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 48,869,153.00 | 38,875,182.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 432,000.00 | 432,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 151,600.00 | 148,200.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 65,835.00 | 126,100.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 66,000.00 | 77,400.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 424,700.00 | 425,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 43,920.00 | 43,920.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 18,015,614.00 | 43,446,297.00 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 18,015,614.00 | 8,700,597.00 |
| 261090 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 18,015,614.00 | 8,700,597.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | - | 34,745,700.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | - | 400,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 34,345,700.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | <u>2,727,575.00</u> | <u>5,439,600.00</u> |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 2,727,575.00 | 5,439,600.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 2,727,575.00 | 5,439,600.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 2,727,575.00 | 5,439,600.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 2,727,575.00 | 5,439,600.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | <u>(2,727,575.00)</u> | <u>(5,439,600.00)</u> |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|-----|---|---------------------------------|-----------------------|-------------------|-------|--|
| 1 | 2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл | - | - | - | - | - |
| 2 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - | - |
| 3 | Тайлант үеийн үр дүн | - | - | - | - | - |
| 4 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 143,918,285.24 | 74,987,661.24 | (7,502,991.95) | - | 211,402,954.53 |
| 5 | 2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл | 143,918,285.24 | 74,987,661.24 | (7,502,991.95) | - | 211,402,954.53 |
| 6 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - | - |
| 7 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 143,918,285.24 | 74,987,661.24 | (7,502,991.95) | - | 211,402,954.53 |
| 8 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - | - |
| 9 | Тайлант үеийн үр дүн | - | - | 57,674,886.82 | - | 57,674,886.82 |
| 10 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 143,918,285.24 | 74,987,661.24 | 50,171,894.87 | - | 269,077,841.35 |




2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Гүйцэтгэлийн зөрүү | Хувь |
|-----------------------|--|-----------------------|----------------|--------------------|--------|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 227,618,700.00 | 219,002,109.00 | 8,616,591.00 | 96.21 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 227,618,700.00 | 219,002,109.00 | 8,616,591.00 | 96.21 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 192,973,000.00 | 184,356,409.00 | 8,616,591.00 | 95.53 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 118,126,100.00 | 111,232,334.00 | 6,893,766.00 | 95.94 |
| 210101 | Үндсэн цалин | 85,846,000.00 | 82,171,994.00 | 3,674,006.00 | 95.72 |
| 210102 | Нэмэгдэл | 29,192,800.00 | 25,973,940.00 | 3,218,860.00 | 88.97 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 3,087,300.00 | 3,086,400.00 | 900.00 | 99.97 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 15,947,100.00 | 14,322,737.00 | 1,624,363.00 | 89.81 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 11,222,000.00 | 10,258,581.00 | 963,419.00 | 91.41 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,181,300.00 | 1,141,724.00 | 39,576.00 | 96.65 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 945,000.00 | 889,859.00 | 55,141.00 | 94.16 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 236,300.00 | 184,780.00 | 51,520.00 | 78.20 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,362,500.00 | 1,847,793.00 | 514,707.00 | 78.21 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 8,242,400.00 | 8,152,636.00 | 89,764.00 | 98.91 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 690,600.00 | 600,878.00 | 89,722.00 | 87.01 |
| 210302 | Түлш, халаалт | 7,039,900.00 | 7,039,858.00 | 42.00 | 100.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 511,900.00 | 511,900.00 | - | 100.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 8,625,200.00 | 8,625,200.00 | - | 100.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 466,900.00 | 466,900.00 | - | 100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 6,370,100.00 | 6,370,100.00 | - | 100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,182,500.00 | 1,182,500.00 | - | 100.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 93,600.00 | 93,600.00 | - | 100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 512,100.00 | 512,100.00 | - | 100.00 |
| 2105 | Нормативт зардал | 205,900.00 | 205,900.00 | - | 100.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 205,900.00 | 205,900.00 | - | 100.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 250,000.00 | 250,000.00 | - | 100.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 250,000.00 | 250,000.00 | - | 100.00 |
| 2107 | Томиллолт, зочны зардал | 1,439,800.00 | 1,439,800.00 | - | 100.00 |
| 210702 | Дотоод албан томиллолт | 1,439,800.00 | 1,439,800.00 | - | 100.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 40,136,500.00 | 40,127,802.00 | 8,698.00 | 99.98 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 38,880,400.00 | 38,875,182.00 | 5,218.00 | 99.99 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 432,000.00 | 432,000.00 | - | 100.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 151,600.00 | 148,200.00 | 3,400.00 | 97.76 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 126,100.00 | 126,100.00 | - | 100.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 77,400.00 | 77,400.00 | - | 100.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 425,000.00 | 425,000.00 | - | 100.00 |
| 210807 | Газрын төлбөр | 44,000.00 | 43,920.00 | 80.00 | 99.82 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 34,645,700.00 | 34,645,700.00 | - | 100.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 34,645,700.00 | 34,645,700.00 | - | 100.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 300,000.00 | 300,000.00 | - | 100.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 34,345,700.00 | 34,345,700.00 | - | 100.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 227,618,700.00 | 219,002,109.00 | 8,616,591.00 | 96.21 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 227,118,700.00 | 218,418,103.00 | 8,700,597.00 | 96.17 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 227,118,700.00 | 218,418,103.00 | 8,700,597.00 | 96.17 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 500,000.00 | 584,006.00 | (84,006.00) | 116.80 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 500,000.00 | 584,006.00 | (84,006.00) | 116.80 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 13.00 | 13.00 | - | 100.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | - | 100.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 6.00 | 6.00 | - | 100.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 3.00 | 3.00 | - | 100.00 |
| 620004 | Гэрээт ажилтан | 3.00 | 3.00 | - | 100.00 |

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|-------------|--|----------------------|
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 10,902,820.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 10,902,820.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 10,802,820.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 191,120.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 191,120.00 |
| 2105 | Нормативт зардал | 4,942,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 4,942,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 5,669,700.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,989,800.00 |
| 210602 | Тавилга | 2,229,900.00 |
| 210604 | Урсгал засвар | 450,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 100,000.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 100,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 100,000.00 |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 10,902,820.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 10,902,820.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 10,902,820.00 |





3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Тужийн нарсны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг бүртгэж байх, ажил гүйлгээг батлагдсан загвар баримт, аргачлалын дагуу хөтлөхтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Цогт гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.


Тужийн нарсны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл: Тужийн нарсны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны эрхэм зорилго нь "Орхон Сэлэнгийн үзэсгэлэнт сав газар орших "ТУЖИЙН НАРС"-ыг хэвээр хадгалан, тэнд оршин байгаа биологийн төрөл зүйлийн экологийн тэнцвэрт байдал, байгалийн өвөрмөц тогтоц, онцлог төрх нь алдагдах элдэв нөлөөллөөс хамгаалах, байгалийн унаган төрхийг хадгалан хойч үеийнхэндээ өвлүүлэн үлдээх"-д оршино.

Тужийн нарсны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Нарсан ойг хамгаалах хууль бус ан, мод бэлтгэлийг таслан зогсоох,
- Нарсан ойг нөхөн сэргээх, унаган төрхийг сэргээх,
- Судалгаа шинжилгээний ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр явуулах,
- Иргэдэд сургалт, сурталчилгаа явуулах, экологийн боловсрол олгох,
- Аялал жуулчлалыг зохистой хөгжүүлэх,
- Гадаад, дотоодын хамтын ажиллагааг сайжруулах, хөгжүүлэх.



Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан,
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” шинэчлэгдсэн,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор УСНББОУС-ын өөрчлөлт, шинэчлэлт хийгдсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзэж байна.

Тужийн нарсны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн зүгээс болон шууд захирагчийн санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.


Тужийн нарсны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн, материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 256,545.4 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 2,565.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувь буюу 1,795.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.



3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тужийн нарсны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 57,674.8 мянган төгрөгөөр буюу 27.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо дансад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1: Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|------------------|------------------|-----------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | | |
| Авлага | | | |
| Урьдчилгаа | | | |
| Бараа материал | 22,141.1 | 31,847.8 | 9,706.7 |
| Үндсэн хөрөнгө | 189,261.9 | 237,230.0 | 47,968.1 |
| Нийт хөрөнгө | 211,403.0 | 269,077.8 | 57,674.8 |
| Өр төлбөр | | | |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 211,403.0 | 269,077.8 | 57,674.8 |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 211,403.0 | 269,077.8 | 57,674.8 |

Бараа материалын дансны үлдэгдэл 31,847.8 мянган төгрөг болж 9,706.7 мянган төгрөгөөр өссөн нь БОАЖЯ-наас 820.0 мянган төгрөгийн /нормын хувцас, тусгай хамгаалалттай нутагт нэвтрэх тасалбар/ бараа материал үнэ төлбөргүй хүлээн авч, төсвийн хөрөнгөөр 26,350.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, 10,956.0 мянган төгрөгийн тэмдэг, тэмдэглэгээг орлогод авсан болон 16,592.0 мянган төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаанд, тэмдэг тэмдэглэгээнд 11,828.2 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 309,475.5 мянган төгрөг болж өмнөх оноос 77,610.5 мянган төгрөгөөр өссөн нь БОАЖЯ-наас 42,640.0 мянган төгрөгийн үнэ бүхий УАЗ- Фургон автомашин, 24,954.8 мянган төгрөгийн гэрээний үнэ бүхий “Тужийн нарсны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны дээвэр, барилгын их засварын ажил”, Монголын ойн чуулган ТББ-ын дэмжлэгээр Шаамар сум дахь мод үржүүлгийн газарт 7,200.0 мянган төгрөгийн үнэ бүхий худгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан болон төсвийн хөрөнгөөр 3,209.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 2,229.9 мянган төгрөгийн

тавилга эд хогшил худалдан авч, 2,623.9 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, устгасантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 269,077.8 мянган төгрөг болж 57,674.8 мянган төгрөгөөр өссөн нь нийт хөрөнгө өссөнөөс шалтгаалжээ.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого өмнөх оноос 75,456.6 мянган төгрөгөөр буюу 31.6 хувиар өссөн байна. Энэ нь үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө 75,614.8 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Тайлант оны нийт зардал өмнөх оноос 14,536.3 мянган төгрөгөөр буюу 6.0 хувиар өссөн нь нормативт зардал болон элэгдлийн зардлууд материаллаг хэмжээгээр нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 272,433.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 272,433.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 40,470.9 мянган төгрөгөөр бууруулж, 231,962.6 мянган төгрөгөөр баталсан байна.

Батлагдсан төсөвт 2021 оны 12-р сард БОАЖЯ-наас өөрчлөлт оруулан 4,343.9 мянган төгрөгөөр бууруулж, 227,618.7 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 227,618.7 мянган төгрөгийн төсөв баталснаас 227,118.7 мянган төгрөгийг улсын төсвөөс, 500.0 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 227,118.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, 11,486.8 мянган төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлого бүрдүүлэн 219,002.1 мянган төгрөгийг зарцуулж, тайлант оны эцэст 8,700.6 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна. Үүнээс 84.0 мянган төгрөг нь үндсэн үйл ажиллагааны давсан орлого, 8,616.6 мянган төгрөг нь цалин, НДШ-ийн зардлын хэмнэлт байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн “Улсын төсвийн байгууллагын үйл ажиллагааны давсан орлогоос зарцуулах эрх олгох тухай” 217 дугаар тушаалын дагуу БОАЖЯ-наас 10,902.8 мянган төгрөгийг нэмэлт төсвийн дансанд шилжүүлэн, 2,229.9 мянган төгрөгийг тавилга эд хогшилд, 4,942.0 мянган төгрөгийг нормын хувцас хэрэглэлд, 2,989.8 мянган төгрөгийг багаж, техник хэрэгсэл худалдан авахад тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

БОАЖЯ-наас нэмэлт төсвийн дансанд шилжүүлсэн давсан орлогоос 4,942.0 мянган төгрөгийн нормын хувцас, 2,229.9 мянган төгрөгийн тавилга, эд хогшил худалдан авсан нь ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4-т “... албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх” гэж заасныг зөрчиж байна.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, ЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Тужийн нарсны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны мэдээлбэл зохих 20 төрлийн 149 мэдээлэл байршуулахаас бүх мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Тужийн нарсны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны тайлант оны үйл ажиллагаанд 227,618.7 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 219,002.1 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 3.8 хувиар хэмнэсэн нь ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: “.....батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй.

3.11 Хойших үйл явдал ба дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 7,450.1 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

4.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны баримт хөтлөлт, бүрдүүлэлттэй холбоотой асуудал

1.1 Бараа, ажил, үйлчилгээний төлбөр тооцооны баримтууд

1.1.1 Илрүүлэлт: Тайлант онд 7,450.1 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

1.1.2 Өгсөн зөвлөмж: Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалт болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасны дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэх.

1.2 Зардлын данстай холбоотой асуудал

1.2.1 Илрүүлэлт: Жолоочийн тооцооны хуудсыг батлагдсан маягтаар хөтлөөгүй, ирсэн, явсан спидометрийн заалтыг бүрэн бүртгээгүй байна.

1.2.2 Өгсөн зөвлөмж: Дээрх зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалт болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар “Маягт заавар батлах тухай” тушаалын хавсралт “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ыг тус тус зөрчсөн тул цаашид батлагдсан жолоочийн тооцооны хуудсыг хөтөлж, холбогдох үзүүлэлтүүдийг бүрэн гүйцэт бүртгэх, шатахууны зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.

Дээрх зөвлөмжүүдийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

| Д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | | | |
|-----|---|----------------------|---------|-----------|-----|---------------|-----|-----------------|-----|---------|-----|---|---------|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | | |
| 1 | Тужийн нарсны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа | 2 | 7,540.1 | - | - | - | - | - | - | - | - | 2 | 7,540.1 |

/мянган төгрөгөөр/

Үүнээс

Залруулга

Төлбөрийн акт

Албан шаардлага

Зөвлөмж

Тоо

Дүн

Тоо

Дүн

Тоо

Дүн

Тоо

Дүн

Тоо

Дүн